



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/316

Арвайхээр

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 14 дүгээр зүйлийн 14.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тарагт сумын нутаг “Их булаг” нэртэй талбайд “Өв идэр” ХХК-д түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 (гурав) жилийн хугацаагаар шинээр олгосугай.

2.Тусгай зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгжийн хайгуулын талбайд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Ч.Гүнсэнхорол), аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Г.Баясгалан), Мэргэжлийн хяналтын газрын дарга (С.Дуламсүрэн), Тарагт сумын Засаг дарга (Т.Нямдаваа) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0677